

АГУУЛГА

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	3
1.1. Төслийн ерөнхий мэдээлэл	3
1.2. Төсөл хэрэгжүүлэх аж ахуй нэгж байгууллага	3
1.3. Төслийн тойм байршил, тойм зураг	3
1.4. Төслийн зорилго	5
1.5. Төслийн хүчин чадал	6
1.6. Гаалийн хяналтын талбайн үйл ажиллагааны дараалал	6
1.7. Гаалийн хяналтын талбайн төслийн давуу тал	6
1.8. Төслийн техник технологи	7
БҮЛЭГ 2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	8
2.1. Физик газарзүйн нөхцөл	8
2.2. Газрын хотгор, гүдгэр	8
2.3. Геологийн тогтоц, хөрс үүсгэгч эх чулуулаг	8
2.4. Уур амьсгалын нөхцөл	9
2.5. Гадаргын ус	9
2.6. Ургамалшил	9
2.7. Хөрсөн бүрхэвч	11
2.8. Амьтны аймаг	13
БҮЛЭГ 3 . ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	15
3.1. Төслийн гол сөрөг нөлөөлөл	15
3.2. Төслийн болзошгүй сөрөг нөлөөлөл	16
БҮЛЭГ 4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ	23
БҮЛЭГ 5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	24
БҮЛЭГ 6. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	28
БҮЛЭГ 7. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	30
БҮЛЭГ 8. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	31
БҮЛЭГ 9. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	33
БҮЛЭГ 10. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	35

БҮЛЭГ 11. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	39
БҮЛЭГ 12. 2025 ОНЫ БОМТ-ИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ХУВААРЬ	41
ДҮГНЭЛТ	42

Зургийн жагсаалт

Зураг 1. Төслийн талбайн байршлын зураг.....	4
Зураг 2. Төсөл хэрэгжих газрын төрх байдал	5
Зураг 3. Чингэлэг өргөх болон буулгах төхөөрөмж	7
Зураг 57. Дээж авах цэгийн байршил.....	38

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. Төсөл хэрэгжих талбайн байршлын координат	4
Хүснэгт 2. Нөлөөллийн үнэлгээний шалгуур ба анхаарвал зохих асуудлууд	15
Хүснэгт 3. Төслийн үйл ажиллагаанаас үүсэж болзошгүй сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	17
Хүснэгт 4. Байгаль орчны нөлөөллийг тоймлох анхан шатны хүснэгт	18
Хүснэгт 5. Болзошгүй сөрөг нөлөөллийн хэмжээ. тархалтын түвшин	19
Хүснэгт 6. Хэмжээ, тархалтаар ерөнхийд нь үнэлсэн үнэгээ	20
Хүснэгт 7. Нөлөөллийн үнэлгээний систем	20
Хүснэгт 8. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	24
Хүснэгт 9. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө	28
Хүснэгт 10. Тэрбум модны зардлын задаргаа	29
Хүснэгт 11. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	30
Хүснэгт 12. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө.....	31
Хүснэгт 11. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	33
Хүснэгт 12. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	36
Хүснэгт 13. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө.....	39
Хүснэгт 14. БОМТ-ний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь.....	41
Хүснэгт 17. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал	44

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1. Төслийн ерөнхий мэдээлэл

Винтрак ХХК-ий Өмнөговь аймгийн Ханбогд сумын 5-р багийн нутаг Гашуун сухайт хилийн боомтод түшиглэн байгуулах Гаалийн хяналтын талбай нь Гааль, татварын ерөнхий газрын 2018 оны 11 сарын 01-ний өдрийн А/301 дүгээр тушаалаар баталсан “Гаалийн хяналтын бүсийн журам”, монгол улсын стандарт /MNS5832:2007/-ын шаардлага хангаж улс хооронд тээвэрлэх нүүрсийг хүлээн авах, хадгалах, ачиж буулгах, гаалийн хяналт хийхтэй холбогдсон иж бүрдэл үйл ажиллагааг зохион байгуулж эхэлсэн.

Гаалийн хяналтын бүсдээ хилийн ойролцоо үйл ажиллагаа явуулдаг нүүрсний уурхайнууд болон Эрдэнэс Таван толгой компанийн олборлосон экспортын зориулалттай нүүрсийг уурхай дээрээс нь чингэлэгт тээвэрт ачиж гаалийн хяналтын бүсдээ хүлээн авч буулган гаалийн хяналт хийлгэн ачуулж ханги хилийн боомт руу явуулах үйл ажиллагаа эрхэлнэ.

Тус талбай нь авто зам, автомашины зогсоол, уул уурхайн эрдэст бүтээгдэхүүний овоолгын талбай, хадгалах хэсэг, операторын байр, оффисын байр, хамгаалалтын байр, гэрэлтүүлэг зэрэг гаалийн хяналтын талбайн бүх шаардлагыг хангасан гаалийн хяналтын бүс юм. 20-25 хүнийг ажлын байраар хангаж ажиллана.

80х100м хэмжээтэй талбайд 1 удаа хүлээн авах чингэлгийн тоо 140, жилд 300000 тонн түүхий эд хүлээн авч буулгах, мөн экспортод гаргана.

1.2. Төсөл хэрэгжүүлэх аж ахуй нэгж байгууллага

Төсөл хэрэгжүүлэгч: “Винтрак” ХХК

Улсын бүртгэлийн дугаар: 000236314

Регистрийн дугаар: 5018439

Газрын гэрчилгээний дугаар: 00000340

Үйл ажиллагааны чиглэл: Автомашинаар ачаа тээвэрлэх, Уул уурхайн чиглэлээр зөвлөгөө өгөх, Автомашины засвар үйлчилгээ

Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг: Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, жамьяан гүний, 14 тоот

1.3. Төслийн тойм байршил, тойм зураг

Тус гаалийн хяналтын талбай нь Өмнөговь аймаг, Ханбогд сум, 5-р баг, 10 га талбайд байрлаж байна. Төслийн талбай нь Гашуун сухайтын авто зам дагуу байрладаг.

Хүснэгт 1. Төсөл хэрэгжих талбайн байршлын координат

№	Уртраг	Өргөрөг	Нийт талбай
1	708955.87	4718337.52	10 га
2	708816.16	4718736.97	
3	709024.12	4718849.45	
4	709167.85	4718444.53	

Зураг 1. Төслийн талбайн байршлын зураг



Зураг 2. Төсөл хэрэгжих газрын төрх байдал



1.4. Төслийн зорилго

Энэхүү төслийг хэрэгжүүлэх гол зорилго нь Гашуунсухайт боомт нь нүүрсний экспортын 51.4 хувь, зэсийн баяжмалын экспортын 55 хувийг нэвтрүүлдэг боловч одоогийн зам талбай, дэд бүтэц, хилийн хяналтын байгууллагуудын үйл ажиллагаа нь өсөн нэмэгдэж буй экспортын хэрэгцээ шаардлагад хүрэлцэхгүй, ачааллаа дийлэхгүйн улмаас 100 гаруй км тээврийн хэрэгслийн дараалал үүсгэж, иргэдийн эрүүл ахуй, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлж байна. Монгол улс нүүрсний экспортыг нэмэгдүүлэх бодлого хэрэгжүүлж байгаа ба гаалийн хяналтын бүсийн хүрэлцээ хүчин чадал дутмаг байгаа дээр үндэслэн чингэлэгт тээврийг нэмэгдүүлэн экспортыг нэмэгдүүлэх, эдийн засгийг өргөжүүлэхэд төслийн зорилго оршино.

Манай компани нь чингэлэгт тээврийг гашуун сухайт боомтын нүүрс тээвэр дээр туршилтад явуулж байгаа болно. Төсөл хэрэгжээд үйл ажиллагааны горимд шилжүүлэн ажиллах явцдаа бүх тээврийн хэрэгслээ чингэлэгт тээвэр болгон үйл ажиллагаагаа үргэлжлүүлнэ.

1.5. Төслийн хүчин чадал

Винтрак ХХК-ний Өмнөговь аймгийн Ханбогд сумын 5-р багийн нутаг Гашуун сухайт хилийн боомтод түшиглэн байгуулах Гаалийн хяналтын талбай нь Гааль, татварын ерөнхий газрын 2019 оны А/294 дүгээр тушаалаар баталсан “Гаалийн хяналтын бүсийн журам”, монгол улсын стандарт /MNS5832:2007/-ын шаардлага хангаж улс хооронд тээвэрлэх нүүрсийг хүлээн авах, хадгалах, ачиж буулгах, гаалийн хяналт хийхтэй холбогдсон иж бүрдэл үйл ажиллагааг зохион байгуулна. Гаалийн хяналтын бүсдээ хилийн ойролцоо үйл ажиллагаа явуулдаг нүүрсний уурхайнууд болон Эрдэнэс Таван толгой компанийн олборлосон экспортын зориулалттай нүүрсийг уурхай дээрээс нь уламжлалт задгай тээвэр болон чингэлэгт тээвэрт ачиж гаалийн хяналтын бүсдээ хүлээн авч буулган гаалийн хяналт хийлгэн ачуулж ханги хилийн боомт руу явуулах үйл ажиллагаа эрхэлнэ. 20-25 хүнийг ажлын байраар хангаж ажиллана. Ажилчдын байрлах байрны хувьд төслийн талбай дотор байрлахгүй бөгөөд уг төсөл хэрэгжүүлж буй компани нь өөр нэгж талбар дээр зөвхөн ажилчдын байрлах, амрах мөн гал тогоо зэргийг багтаасан байрлах кемп байгуулсан.

1.6. Гаалийн хяналтын талбайн үйл ажиллагааны дараалал

1. Уурхайгаас ачиж ирсэн уламжлалт задгай болон чингэлэгт тээврийн түүхий эдийг стандарт журмын дагуу аюулгүй найдвартай зориулалтын талбайд буулгах
2. Буусан түүхий эдийг найдвартай стандартад нийцсэн талбайд хадгалах
3. Талбай дахь задгай болон чингэлэгтэй ачааг чингэлэг ачиж буулгах ачигчаар ачиж пүүлүүлэн лацдаж, гаалийн хяналтад бүрдүүлэлт хийн Ханги хилийн боомт руу явуулна.

1.7. Гаалийн хяналтын талбайн төслийн давуу тал

Нүүрсний овоолгыг уурхайн чингэлэгт тээвэрт ачиж шууд эцсийн хэрэглэгчдэд хүргэж өгснөөр олон удаагийн нүүрс ачиж буулгах явцыг багасгаж, үүнээс үүсэж буй материалын хорогдол, агаарын бохирдол, тоосжилт зэрэг байгаль орчны асуудлуудыг цогцоор нь шийдэх юм. Нүүрс ачиж буулгах явц бүрд дунджаар 250-400кг/машин жингийн зөрүү үүсдэг. Тиймээс уг төслийг хэрэгжүүлснээр материалын хорогдлыг бууруулах давуу талтай болох юм. Чингэлэгт нүүрс ачиж буулгах дэвшилтэт технологи /KALMAR маркийн өргөх буулгах төхөөрөмж/-ийг нэвтрүүлнэ. Ингэснээр нүүрс буулгах болон ачих хугацааг багасгаж тээврийн хэрэгслийн сул зогсолтыг бууруулж, ажлын бүтээмжийг нэмэгдүүлнэ.

Зураг 3. Чингэлэг өргөх болон буулгах төхөөрөмж



1.8. Төслийн техник технологи

Гаалийн хяналтын талбайд доорх тоног төхөөрөмжийг ашиглана. Үүнд:

- Нүүрс ачих дугуйт ачигч /ковш/ - 4ш
- Чингэлэг буулгах болон ачих төхөөрөмж /KALMAR/ - 2ш
- Суудлын автомашин – 2ш
- Цахилгаан үүсгүүр – 2ш
- Авто пүү – 2ш

БҮЛЭГ 2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

2.1. Физик газарзүйн нөхцөл

Өмнөговь аймаг Ханбогд сум Хайрхан 5-р баг, 10 га талбайд гаалийн хяналтын талбай байгуулан ажиллаж байна. Ханбогд сум нь газарзүйн мужлалаар цөлийн ландшафттай говийн мужид хамаарах бөгөөд газарзүйн хэлбэр, гадаргуугийн хэв шинжээр Э.М.Мурзаев цав толгод, ухаа гүвээт талын хэв шинжид багтаан үзжээ. Хуурай сайраар хэрчигдсэн, үнэмлэхүй өндөр нь 900-1100 м, орой хяр нь хавтгай ба бөмбөгөр хэлбэртэй, хажуу нь налуу хад асга багатай цав толгод болон ухаа гүвээт тал зонхилдог. Ханбогд сум нь Монголын говь цөлийн бүсийн өмнөд хэсэгт байрладаг ба Ханбогд уулын орчимд орших говийн намхан толгодоос тогтдог. Говийн бүсдээ харьцангуй өндөрт тооцогдох уулуудтай ба үүнд Ханбогд уул (д.т.д 1350 м), Бумбат задгайн хяр (д.т.д 1233.3 м), Жавхлант уул 1295 м (д.т.д), Далайн Дуулга (д.т.д 1240 м) зэрэг уулс орно. Ханбогд сумын нутагт 1400 метрээс дээш өндөртэй уулс оршино. Сумын баруун хойд хэсэг нь тэгш тал, түүнээс ялимгүй урд хэсгээр цав толгод байдаг. Голын хурдаст тал нь нутгийн хойд хэсгийн багахан нутгаар зурвас байдлаар оршино. Нутгийн өмнөд хэсгийн нэлээдгүй талбайд жижиг толгод бүхий нам уулстай. Дорнод Монголын талын урд хэсэгт, хуурай хээр, говийн экосистемд, тэгш тал, уудам хөндий хотгорын системд байрлах бөгөөд экосистемийн хувьд элсэн хучаас бүхий говийн бор болон заримдаг цөлийн цайвар бор хөрсний хэв шинж зонхилон тархсан бөгөөд ургамал бүрхэвчийн хувьд сийрэг заг болон цулхират цөлөрхөг хээрийн бүсийн Заг, харгана, хамхуул, лууль зэрэг ургамал бүрхэвч зонхилсон шинжтэй байна.

2.2. Газрын хотгор, гүдгэр

Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт байрлах гаалийн хяналтын талбай нь Монгол орны зүүн өмнөд хэсэгт, Дундговь-Өмнөговийн мужийн Галба-Өөшийн говийн бүсэд байрлана. Тус бүс нутагт нь өндөр уул нурууд байхгүй, уулс хоорондын болон тэгш тал, хөндий хоолой зонхилон тархдаг онцлогтой байна. Газрын хотгор, гүдгэрийн үндсэн хэв шинжид элэгдлийн суурьт давхаргат тал, ухаа гүвээт, нугачаат тэгш тал, голын болон нуурын хурдаст талын хэв шинж голчлон илэрнэ.

2.3. Геологийн тогтоц, хөрс үүсгэгч эх чулуулаг

Төсөл хэрэгжиж буй талбай орчмын хөрс үүсгэгч эх чулуулаг нь пролювийн элс, элсэнцэр хурдаснаас тогтоно. Ийм гаралтай пролювийн хурдас нь Монголын дорнод хэсгийн элэгдэл-хуримтлалын гаралтай ухаа гүвээт тал болон тэгшивтэр талуудад түгээмэл тохиолдоно. Эдгээр хурдас нь элс, элсэнцэр механик бүрэлдэхүүнтэй, карбонатын агууламж өндөртэй, хөрсний үе давхаргуудад элсэн фракцын агууламж өндөр, нам дор газруудад хүнд шавранцар бүтэцтэй байдаг.

2.4. Уур амьсгалын нөхцөл

Гаалийн талбай байгуулахаар төлөвлөж буй талбай нь Монгол орны хамгийн дулаан бүсэд багтдаг бөгөөд уур амьсгалын мужлалаар хэт халуун хуурай зунтай, хүйтэн, хуурай өвөлтэй мужид багтана. цаг агаарын хэмжилтийн дүнгээс үзэхэд зуны улирлын агаарын дундаж температур +20ОС байх бол өвлийн улирлын дундаж температур -17ОС орчим бол жилийн дундаж температурын хэмжээ +3ОС орчимд хэлбэлзэнэ.

Жилд дунджаар 90-100мм орчим хур тунадас унах бөгөөд нийт хур тунадасны 80% зөвхөн дулааны улиралд 4–р сараас 10-р сарын хугацаанд ногдоно. Хур тунадасны ихэнх хувь нь дулааны улиралд унах учир өвлийн улиралд цастай өдрийн 1-3 орчим байх бөгөөд тогтвортой цасан бүрхүүл тогтдоггүй байна. Улирлын хөлдөлт гэсэлтийн гүн хөрсний механик бүрэлдэхүүн болон чийгийн агууламжтай уялдаатайгаар 30см хүртэл гүнд хэлбэлзэнэ. Салхитай өдрийн тоо жилд 30-40 орчим байх бөгөөд үүнээс шороон шуургатай өдрийн 40 дээш орчим буюу нийт жилийн турш маш их хүчтэй салхины нөлөөнд оршдог байна. Уур амьсгалын нөхцөлийн хуурай- чийг багатай, хүчтэй салхины нөлөөнд оршдог шинж нь төслийн талбайн хөрсөн бүрхэвчийг хуурай, элсэн фракц давамгайлсан, органик бодисын нөөц багатай, давсны агууламж өндөр, карбонатын агууламж их зэргээр илэрдэг.

2.5. Гадаргын ус

Гаалийн талбайн орчимд гадаргын усны хэлбэр байхгүй. Ус зүйн сүлжээгээр Төв Азийн гадагш урсгалгүй ай савд багтах ба Гидрогеологийн мужлалаар улирлын хомс тэжээлтэй районд багтдаг. Нам өндөртэй хад чулуурхаг, говь маягийн уулсаас зуны хур борооны усаар үүсэх үер, гадаргын усны

2.6. Ургамалшил

Ургамал газарзүйн мужлалаар тухайн бүс нутаг нь Сахар-Говь цөлийн их мужийн Төв Азийн мужийн Өлгий хийд- Галбын говийн бүсийн бутлаг үетэнт ба заримдаг сөөгөнцөр, бутлаг үетэнт цөлжүү хээрт хамрагдах ба тэнд ихэвчлэн хазаар өвс-хялганат, хялганат, агь-хазаар өвс хялганат, харгана бүхий агь-хазаар өвс-хялганат, чулуусаг алаг өвс-агь-үетэнт ургамлын бүлгэмдэл зонхилно. Төсөл хэрэгжих талбайд салхиар зөөгдөж хуримтлагдсан элсэн товцог, довон үүссэн бөгөөд үерийн усны хуримтлалын шал, тойром, хотос элбэгтэй. Элсэн товцог бүхий газруудаар цагаан шаваг, цагаан суль, харганы холимог сөөг бүхий бэлчээр илрэхээс гадна харган, заг бүхий өтгөн шугуй тархана.

Ханбогд сум нь ургамал газарзүйн мужлалаар тухайн бүс нутаг нь Сахар-Говь цөлийн их мужийн Төв Азийн мужийн Өлгий хийд- Галбын говийн бүсийн бутлаг үетэнт ба заримдаг сөөгөнцөр, бутлаг үетэнт цөлжүү хээрт хамрагдах ба тэнд ихэвчлэн хазаар өвс-хялганат, хялганат, агь-хазаар өвс хялганат, харгана бүхий агь-хазаар өвс-хялганат, чулуусаг алаг өвс-агь-үетэнт ургамлын бүлгэмдэл зонхилно. Төсөл хэрэгжих талбайд салхиар зөөгдөж хуримтлагдсан элсэн товцог, довон үүссэн бөгөөд үерийн усны хуримтлалын шал, тойром, хотос элбэгтэй. Элсэн товцог бүхий газруудаар цагаан шаваг, цагаан суль, харганы холимог сөөг бүхий бэлчээр илрэхээс гадна харган, заг бүхий өтгөн шугуй тархана.

Ургамалжилтын онцлог, ургамлын зүйлийн бүрдэл Ханбогд сумын нутгийн ургамлын аймгийн хувьд баруун хойд хэсэг нь Дорноговийн цөлөрхөг хээрийн тойрогт үлдсэн ихэнх хэсэг нь Алашаа говийн цөлийн тойрогт хамаарагдана.

Уг сумын нутгийн бэлчээрийн ургамалжилт Зэрэгцээ толгой, Их Хонгор уул орчимд Баглуур-Монгол өвст, Баглуур-бударганат, цөлжилтийн нөлөөтэй уулсаар (Дэмчог хийд орчим, Ханбогд уул, Дөрвөлжин Толгой орчимд) болон цөлийн уулсаар (Номгон уул) Шар мод-баглуурт хэвшил зонхилно. Таван толгойн талаар Баглуур-Монгол өвст, тэсэгтэй, шар модот, Хээгийн элс, Гүний элсэн талаар Хазаар өвс-тэсэгт, Тэсэг-хойргот хэвшилтэй бол Галбын говиор Баглуурт цөл, Арзгар хамрагт цөл зонхилно. Уртын гол, Бага мод, Умдайн сайр, Цагаан Хад, Дайчингийн заг зэрэг нэн ховор, ховор, унаган, эмийн ашигт ургамал ихтэй газрууд олон байдаг байна.

Ханбогд сумын ургамлын аймагт 35 овог, 100 төрөл, 161 зүйл бүртгэсэн нь цөл судлаач Санчидын бүртгэсэн 242 зүйл ургамлын 66.5% болж байна.

Дээрх бүлгэмдлүүдэд 10 м² талбайдаа 8-35 зүйлтэй, 1 м² талбайд 3-10 зүйл ургамалтай, Баглуур, шар мод, хотир, Монгол өвс, таана, бударгана, тэсэг зонхилсон, доройтсон бэлчээртээ Үслиг манан-хамхаг (*Bassia dasyphylla* (Fisch. et Mey.), Харлаг өмхий өвс (*Peganum nigellastrum* Bge.), Толгодын бударгана (*Salsola collina* Pall.), Ktze.), бусад хөл газрын ургамал түрж ургасан төрхтэй байна. Ургамалжлын хувьд ургамлан нөмрөгийн тусгаг бүрхэц 11.6-39.6%, халцгай газар 18.8-63.2% эзэлж, ургац 0.82-1.142 ц/га болсон байна. Нийт 15 овог, 32 төрөл, 35 зүйл ургамал бүртгэв. 1м²-д 4-6 орчим зүйл тааралдаж байв. Ургамлын бүрхэц 21.4%, түүнээс талхагдлын заагуур ургамал 6.2%, нийт гадаргын бүрхэцэд хайрга чулуу 15.4%, хагдгүй, халцгай газар 63.2% байна.

Терминал (ачиж буулгах талбай) төсөл барилгын үйл ажиллагаанаас болон байнгын үйл ажиллагаанаас ургамлан нөмрөгт талхагдал, доройтлын дараах түгээмэл хэлбэр, өөрчлөлтүүд үүснэ. Үүнд:

- Гаалийн хяналтын талбай орчмын ургамлан нөмрөгийн биомассын нөөц хомстох, талхлагдах
- Авто зам, төмөр зам орчмын ургамал бүрхэц сийрэгжсэнээр хөрс эвдрэх үйл явц түргэсэх
- Ургамлан нөмрөгийн бүлгэмдэл болон зүйлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт гарч, зүйлийн тоо багасах
- Талбайг барьж байгуулах явцад ашиглагдах хурдас чулуулаг, барилгын материал, техник тоног төхөөрөмжийн хог хаягдлаар эрүүл ургамлан нөмрөгтэй газар дарагдах
- Механик үйлчлэлээр (машины дугуй, хүний хөл) талхлагдаж сийрэгжих, ургамлын нийт бүрхэц багасах
- Эвдэрч доройтсон ургамлан нөмрөгт хог ургамлын зүйлийн тоо нэмэгдэх

Төсөл хэрэгжүүлэхээр төлөвлөж буй талбайн гадаргаар ургасан ургамлан нөмрөг ажилчдын байр, төмөр замын талбай зэрэгт дарагдана. Мөн тээвэрлэлт хийх үед боссон тоос шороо нь ойр орчны эрүүл хөрсөнд бууснаар ургамлан бүрхэвч болоод хөрсний чанарт сөргөөр нөлөөлөх болно. Ургамал тоосонд дарагдсанаар фотосинтезийн процесст сөргөөр нөлөөлж улмаар өсөлт хөгжилд нь сөргөөр нөлөөлдөг.

Тоосжилтоос ургамалд учруулах нөлөөлөл: Төсөл хэрэгжих орчны ургамлан нөмрөгт үзүүлэх гол сөрөг нөлөөлөл нь агаараас буух тоосны хуримтлал юм. Энэхүү тоосжилт нь салхиар зөөгдөн ирэх магадлалтай. Төслийн үйл ажиллагаанаас үүсэх тоос нь ургамлын эд эрхтэн дээр бууж удаан хугацаанд хуримтлагдсанаар ургамлын фотосинтезийн эрчмийг бууруулж улмаар ургамлын ургалт буурах, өсөлт хөгжилт зогсох нөхцөлийг бүрдүүлдэг. Төслийн ашиглалтын талбай, хөрс, овоолго, ачиж буулгах болон гадаад, дотоод тээвэрлэлтийн явцад хуурайшилт болон салхины хурднаас хамаарч ямар нэгэн хяналтгүйгээр тоосжилт үүсэх ба энэ нь салхины чиглэлийн дагуу, салхины хурдас хамаарч тархалтын хил нь 3.0 км хүртэл байна.

2.7. Хөрсөн бүрхэвч

Төслийн талбай нь хөрс- газарзүйн мужлалын хувьд говийн хөрс -био уур амьсгалын их мужийн өргөргийн бүсшилийн хэв шинж бүхий цөлийн бор саарал хөрсний 14-р Галбын говийн тойргийн нутагт багтана. Тус тойрогт говийн цөлөрхөг хээрийн бор хөрс (Хээржүү цөлийн цайвар бор, говийн бор хөрс) голчлон тархах бөгөөд нам өндөртэй цав толгодуудаар сайр чулуурхаг говийн бор хөрс, түүнтэй бэл болон ам хөндий газраар цайвар бор хөрс, бусад нам дор хотос газруудаар сул элсэн болон эсэн хучаастай хөрс зонхилон тархсан шинжтэй. Гаалийн талбайн дийлэнх хэсэгт элсэн хучаас бүхий говийн бор хөрс тохиолдоно. Төслийн талбайд тархсан элсэн болон говийн бор хөрс нь сийрэг ургамал бүрхэвчтэй, үндэсний тархалтын гүн 30 орчим, хөрсний үе давхаргад чулуугүй, гүндээ давсжилтын нөлөөгөөр нягтшил нэмэгдсэн, хөрсний гадаргад элсний хучаас үүссэн зэрэг шинжүүд илэрч байна.

Төслийн талбайд тархсан зонхилох хэв шинжийн товч тодорхойлолтыг Акад Д.Доржготов (2003) “Монгол орны хөрс” бүтээлээс хэсэгчлэн оруулав. Монгол орны хуурай гандуу бүс нутагт зонхилон тархах, говийн бүсийн заримдаг цөлийн цайвар бор болон элсэн хучаастай, сийрэг элсэн хөрсний зонхилох хэв шинжүүд нь эх газрын хуурай, халуун уур амьсгалтай нөхцөлд тогтворждог, хөрсний өнгөн хэсэг, дээд үеүд нь хүчтэй халж, ургамлын үлдэгдлийн эрдэсжих үйл явц эрчимтэй явагддаг тул органик бодисын хуримтлал нь өөрчлөгдөж ялзмагт хуримтлалын давхарга нь илэрч харагдахгүй, бордуу өнгөтэй хатуувтар өнгөн үе мэдрэгддэг. (Доржготов, 2003: Умаров ба бусад, 1978: Даваажамц, 1974: Батхишиг, 2008: Даваадорж ба бусад, 2009).

Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт байрлах “Винтрак” ХХК-ийн “Цагаан Хад” гаалийн 13.6 га талбай нь хөрс- газарзүйн мужлалын хувьд говийн хөрс -био уур амьсгалын их мужийн өргөргийн бүсшилийн хэв шинж бүхий цөлийн бор саарал хөрсний 14-р тойрог болох Галбын говийн бүс нутагт багтана [Үндэсний атлас, 2009]. Тус тойрогт говийн цөлөрхөг хээрийн бор хөрс (Хээржүү цөлийн цайвар бор, говийн бор хөрс) голчлон тархах

бөгөөд нам өндөртэй цав толгодуудаар сайр чулуурхаг говийн бор хөрс, түүнтэй бэл болон ам хөндий газраар цайвар бор хөрс, бусад нам дор хотос газруудаар сул элсэн болон эсэн хучаастай хөрс зонхилон тархсан шинжтэй.

Төсөл хэрэгжих талбайн зонхилох хөрсний хэв шинжийг илрүүлэх судалгаанд талбайн хөрсний суурь зураг мөн хөрсний үе давхаргыг ил гаргасан морфологи зүсэлт гүйцэтгэн, хими, физик шинж чанарыг тодорхойлох зорилгоор лабораторийн задлан шинжилгээнд зориулж үе давхарга тус бүрээс дээж авдаг.

Цөлийн бор саарал хөрс: Сөөг, сөөгөнцөр, бутлаг ургамал зонхилсон цөлийн ургамалшил маш сийрэг тархай байдалтай бүс нутгуудад голчлон тархана. Хөрсний гадарга өрөмтөн дарайж тогтсон хатуувтар өнгөн тавих үе (К), түүний доод талд орших хуудас шиг үелсэн бүтэцтэй (Q) үе ялгарна. Хөрс үүсгэгч эх чулуулаг нь голдуу пролюви, делюви-пролювийн гаралтай сайр чулуурхаг хөнгөн шавранцар, элсэнцэр хурдас байх тул хөрсний бүх үе давхарга сайр чулуутай. Ширхгийн бүрэлдэхүүний хувьд хөнгөн шавранцар, элсэнцэр хөрс зонхилох ба наанги шаврын агууламж Bt , Bt , Ca давхаргад ялимгүй ихсэх хандлага ажиглагдаж буй нь шавар үүсэх явцын илрэл юм.

Талбайн хэмжээнд тархсан цөлийн бор саарал хөрсний өнгөн гадарга талхагдал, эвдрэлд орсноос, цөлийн элс-сайр чулуун хучаас үгүй болсон байна. Хөрсний ялзмагийн хэмжээ харилцан адилгүй карбонаттай бор саарал хөрсний 0-10 см-т 1,37%, бусад хөрсөнд 0,44-0,59% хүрэх төдий агуулагдсан, хөрсний урвалын орчин pH -9,1-9,3 хүрч их шүлтлэг орчинтой. Хөрс өнгөнөөсөө болон бүх давхаргад карбонат бага хэмжээгээр агуулсан $CaCO_3=0,46-1,88\%$ байна. Хөрсөнд агуулагдах давсны агууламж өндөртэй 0,46-1,88% хүрч, цахилгаан дамжуулах чанар идэвхэжсэн EC 2,5-3,450-3,460 dS/m байна. Давсны агууламж карбонаттай болон мараалаг бор саарал хөрсөнд илүүтэй байна. Ургамалд хялбар ашиглагдах шим тэжээлийн бодисын агууламж фосфороор бага, кали дундаас доош хангамжтай байсан байна.

Харин 2024 оны хөрсний үржил шимийн түвшнийг илэрхийлэх ялзмагийн хэмжээ дээжид 1.63-2.73%-ийн хооронд хэлбэлзэж байна. Карбонатын агууламж өнгөн үеэс доошлох тусам багасаж байна. Хөрсний урвалын орчин бүх хөрсөнд дунд шүлтлэгээс хүчтэй шүлтлэг шинжтэй байх ба хэмжээ нь 7.70-8.50 хооронд хэлбэлзэнэ. Хөрсний цахилгаан дамжуулах чадвар (EC) нь тухайн хөрсөнд агуулагдах давсны хэмжээг илэрхийлнэ. EC -ийн хэмжээ бидний судалгааны дүнгээр талбайн хөрсөнд бага хэмжээтэй (0.650-1.415 dS/m) агуулагдаж байна. Эндээс үзэхэд хөрсний ялзмагийн агууламж буурч, шим тэжээлийн элемент болох фосфор-ийн агууламж буурсан байна.

Төслөөс газрын гадарга, хөрсөн бүрхэвчид үзүүлэх болзошгүй сөрөг нөлөөлөл

Терминал (ачиж буулгах талбай) төсөл явагдах үйл ажиллагааны явцад хөрсөн бүрхэвчид эвдрэл, ачиж буулгах талбай нь дараах түгээмэл хэлбэр, өөрчлөлтүүд үүснэ. Үүнд:

- Терминал (ачиж буулгах талбай) төсөл орчим нь сийрэг, элсэнцэр бүтэцтэй байгаа нь ус нэвтрүүлэх чадвар өндөртэй учир хөрсөнд ямар нэг уусамтгай болон шингэн хаягдал алдагдсан тохиолдолд хурдан нэвчиж тархах аюултай.

- Авто машин, хүнд техникийн нөлөөгөөр хөрсний гадаргын ургамал бүрхэц сийрэгжих хөрс эвдрэх, нягтарч хатуурах, бүтэц алдагдах хөрсний хими, физик, геохими, биохимийн хөдлөл зүйн горим өөрчлөгдөх
- Механик үйлчлэлээр (машины дугуй, хүний хөл) хөрс талхлагдаж сийрэгжих, нимгэрэх
- Хөл газрын ургамал түрэн ургах, нутгийн унаган ургамлыг түрэх, дарангуйлах
- Ухсан газарт ландшафтын эвдрэл үүсэж, хөрсний генетик үе давхаргууд холилдон морфологи тогтоц бүрмөсөн алдагдах
- Хөрс салхинд хийсэж элэгдэж эвдрэх үйл явц нь ихсэн тоосжилт нэмэгдэх зэрэг болно.

Мөн тээвэрлэлт хийх үед боссон тоос шороо нь ойр орчны эрүүл хөрсөнд бууснаар ургамлан бүрхэвч болоод хөрсний чанарт сөргөөр нөлөөлөх болно. Талбайгаас ачилтад ашиглагдах автомашин, тээврийн хэрэгслүүд замгүй газраар явж хөрсөн бүрхэвчийг гэмтээж болзошгүй юм. Хөрсний эвдрэл түүний ямар шинжийг хамарч байгаагаар нь механик, биологийн, химийн, геохимийн гэж ангилдаг бөгөөд хүний үйл ажиллагааны нөлөөгөөр эвдэрсэн газарт эдгээр эвдрэлийн үйл явц ихэвчлэн зэрэг явагдах магадлалтай.

Хөрс усаар эвдрэх: Бороо, цас, үерийн ус газрын гадаргаар урсахдаа хөрсний өнгөн хэсгээс эхлэн үржил шимтэй тоосорхог жижиг хэсгийг арчин угааж хөрсөнд ан цав үүсгэдэг. Нөгөө талаар төслийн талбай нь байнгын хүнд даацын автомашины хөдөлгөөний эрчим их байх тул ургамал бүрхэвчийг доройтуулахаас гадна хур бороо ихтэй үед машины зам, дугуйн дагуу эвдэрсэн ховилоор нь ус урсаж, хөрс эвдэрч гэмтэнэ. Төсөл хэрэгжих талбай нь харьцангуй тэгш ч үйл ажиллагааны улмаас хур бороотой үед хөрс усаар угаагдаж эвдрэл доройтлын эрчмийг нэмэгдүүлэх магадлалтай. Иймээс үерийн усаар хөрс эвдрэхээс сэргийлэх, хөрсийг хамгаалах зорилгоор ногоон байгууламжийг хэсэгчлэн байгуулах хэрэгтэй.

Хөрсний бохирдол: Хөрсийг бохирдуулж болзошгүй эх үүсвэрүүдэд тээврийн хэрэгслээс ялгарч буй хорт нэгдэл, хог хаягдал бохир ус зэрэг орно. Эдгээр бохирдлын эх үүсвэрээс гарсан хүхэрлэг хий, нүүрстөрөгчийн дутуу исэл, азотын давхар исэл, тоос зэрэг нь байгаль орчныг бохирдуулж хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх магадлалтай. Иймд техник хэрэгслийн шатахуун, тосны асгаралтаас гарах бохирдлыг тэр даруй цэвэрлэж, хөрс шороогоор булах нь зүйтэй. Машин, техникийн зогсоол, хүний хөлийн газрын хөрс ихээр талхлагдаж, өнгөн хөрс нь суларч, сийрэгжин, сул шороо ихтэй болдог.

2.8. Амьтны аймаг

Винтрак ХХК-ийн Гаалийн хяналтын талбайд зэрлэг ан амьтан байхгүй мөн. Тус талбай нь битүү хашаатай, хамгаалалттай учир нохой, муур болон 5 хошуу мал орох боломжгүй юм.

Өмнөговь, Дорноговь, Сүхбаатар, Дорнод, Хэнтий аймгийн цагаан зээрийн дэлхэц нутгийн 50 гаруй хувийг хамруулан 1994 онд хоёр онгоцоор зэрэг нислэг хийж 2 сая 670 мянган зээр байгааг тогтоосон (Лущекина, 1990; Milner-Gulland et al., 1998; Mix et al., 1995).

Б.Лхагвасүрэн Дорнод, Хэнтий, Сүхбаатар, Дорноговь аймгийн цагаан зээр тархсан нутгийн 31.5%-ийг хамран 15,995 км замлалд 1997 онд тооллого хийж, 814,352 толгой зээр үзэж тэмдэглэсэн. Тооллогын материалыг нэгтгэн боловсруулахад нийт 500,000 орчим км² нутагт 2.3 сая толгой цагаан зээр тархсан байна (Лхагвасүрэн, 2021). Үндэсний хэмжээний 2002 оны судалгаагаар Дорнод Монголын цагаан зээрийн тоо толгойг 800,000-900,000 гэж үнэлэв (Olson нар, 2005).

Судалгааны хугацаанд хилийн харуулын ахлагчаас боомт орчимд ажиглагддаг том хөхтөн амьтдын талаар асуухад дээд тал нь 20-30 хүртэл тоогоор сүрэглэсэн хулангууд тус талбайгаар дайран өнгөрдөг талаар дурдаж байсан. Kaczensky (2006) нарын хиймэл дагуулын дохиолол дамжуулагч ашиглан гүйцэтгэсэн хулангийн тархац, байршилтын судалгаагаар боомт орчимд 2005-2006 онд хулан дайран өнгөрч байсан нь тодорхой байна.

БҮЛЭГ 3 . ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

3.1. Төслийн гол сөрөг нөлөөлөл

Өмнөх шатанд тодорхойлогдсон болзошгүй болон гол сөрөг нөлөөллүүд, түүний үйлчлэлд өртөх нутаг дэвсгэрийн байгаль орчин, нутгийн оршин суугчид, түүх, соёлын өвд бий болох сөрөг үр дагавар, түүний эрчим, цар хүрээ, шууд болон шууд бус нөлөөллүүд, болзошгүй хуримтлагдах нөлөөллийг Монгол улсын хууль тогтоомжид заасан болон олон улсын нийтлэг аргуудыг ашиглан үнэлэв.

Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд учруулж болзошгүй сөрөг нөлөөллүүдээс цаашид төсөл хэрэгжих явцад агаарын чанар, хөрсөн бүрхэвчийн бохирдолд үзүүлэх сөрөг нөлөөллийг хамгийн бага хэмжээнд байлгах тал дээр илүү түлхүү анхаарч, хяналт тавин ажиллах шаардлагатай. Мөн төслийн гол сөрөг нөлөөллүүдийг доорх байдлаар нэгтгэн харуулав.

Хүснэгт 2. Нөлөөллийн үнэлгээний шалгуур ба анхаарвал зохих асуудлууд

Байгаль орчин/ нийгмийн асуудлууд	Орон нутгийн хэмжээнд байгаль орчин, нийгэмд үзүүлж буй аливаа үйл ажиллагаа, бүтээгдэхүүн, үйлчилгээний нөлөөлөл. Хамгийн их нөлөө үзүүлж байгаа асуудлыг хамгийн ноцтой асуудал гэж тооцно.
Байгаль орчин /нийгмийн элемент буюу нөлөөлөлд өртөж болзошгүй параметрууд	Байгалийн физик шинж чанар: Агаарын чанар, чимээ шуугиан, газрын доорх усны төлөв байдал, чанар, хөрсний чанар, геоморфологи Биологийн буюу экологийн нөөц баялаг:Ургамал, амьтан, ургамал амьтан, тусгай хамгаалалттай газар нутаг, дархан цаазтай амьтан ургамлын төрөл зүйл Хүний хэрэглээний үнэ цэнэ: Аж үйлдвэр, зам тээвэр, хөдөө аж ахуй, орон нутгийн усны хангамж, орон нутаг дахь хаягдал усны менежмент, хатуу хог хаягдлын менежмент, эрчим хүчний хэрэглээ, цахилгаан эрчим хүчний хангамж Амьдралын чанар: нийгмийн үнэ цэнэ, нийгэм-эдийн засаг, боловсрол, археологийн үнэ цэнэ, байгалийн үзэсгэлэн, эрүүл мэнд, аюулгүй байдал
Хууль эрх зүйн шаардлага	Тухайн үйл ажиллагааг гүйцэтгэх арга хэлбэрийг заасан журмуудыг батлан гаргана.
Байгаль орчны нөлөөллийн далайц	Бараа материал, тоног төхөөрөмжийн ханган нийлүүлэлт, мөн уул уурхайн эрдэст бүтээгдэхүүний тээвэр ложистикийн төвийг байгуулах учир тоосжилт багасан.
Нөлөөлөл үүсэх газар зүйн байрлал	Гаалийн хяналтын талбайн Ханбогд сумын нутаг дэвсгэр буюу өөрийн эзэмшлийн 10 га талбайд явагдана. .

Нөлөөлөл үргэлжлэх хугацаа давтамж	Гаалийн хяналтын талбайн барилга байгууламжийн явцад тоног төхөөрөмжөөс дуу чимээ тархана. Тоосжилт болон дуу чимээ нь бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн явцад л тархах үргэлжлэх хугацаа богино юм. Харин цаашид ашиглалтын явцад төмөр замын дуу чимээ нэмэгдэнэ.
Хүмүүст нөлөөлөх байдал	Төсөл хэрэгжих талбайн ойр орчимд тээврийн зам, төмөр зам байгаа хэдий ч, суурьшлын бүс байхгүй байна. Төслийн үйл ажиллагаанаас үүсэх тоосжилт, дуу чимээ нь талбайд ажиллаж байгаа ажилчдад нөлөөлнө.
Нөлөөллийн эрсдэл	Болзошгүй нөлөөлөлд тус үйлдвэрийн хашаалсан талбай болон ажилчид өртөнө.
Нийгэм эдийн засгийн хувьд үзүүлэх нөлөө	уул уурхайн компаниуд болон Өмнөговь аймгийн хүн амын хүнс, бараа материал, тоног төхөөрөмжийн ханган нийлүүлэлт, мөн уул уурхайн эрдэст бүтээгдэхүүний тээвэр ложистикийн төвийг байгуулж авто замаар явах хүнд даацын автомашины хэрэглээг багасгаж, авто тээврийн осол аваар, байгаль орчны бохирдлыг бууруулж, ачаа тээврийн ханган нийлүүлэлтийг баталгаатай, найдвартай, хурдан шуурхай болгон сум орон нутаг болон Монгол улсын эдийн засагт тодорхой хувь нэмэр оруулна.
Нөхөн сэргээж болох эсэх	Төслийн талбайн 20-оос доошгүй хувьд ногоон байгууламж байгуулах шаардлагатай.
Институтийн чадавх	Орон нутгийн засаг захиргааны байгууллагууд нөлөөллийн асуудлаар ажиллах чадавх сул байдаг. БОУАӨЯ болон үнэлгээний мэргэшсэн ХХК-уудаас туслалцаа авах шаардлагатай гэж үзэж байна.
Байгаль орчин, нийгэм эдийн засгийн үзүүлэлт	Байгаль орчинд дунд зэргийн сөрөг нөлөөтэй, энэ нь богино хугацаанд нөлөөлөл үзүүлнэ. Улс болон орон нутгийн эдийн засагт эерэг нөлөөлөлтэй.
Нөлөөллийн нийт үнэлгээ	Нөлөөлөл дунд зэрэг боловч богино хугацаагаар үргэлжлэх эрсдэлтэй. Нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, нөлөөллийг бууруулах, аюулгүй ажиллагааны зааварчилгааг нарийн чанд сахиж ажиллах шаардлагатай.

3.2. Төслийн болзошгүй сөрөг нөлөөлөл

Төслийг хэрэгжүүлэхэд байгаль орчин болон ард иргэдэд нөлөөлж болзошгүй гол хүчин зүйл нь түүхий эд материалыг тээвэрлэх болон ажилчдын аюулгүй ажиллагаа байна. Үүнтэй холбогдуулан сөрөг нөлөөллийн түвшин их, дунд, бага, нөлөөлөлгүй гэсэн үзүүлэлтээр нөлөөллийн үнэлгээг нарийвчлан хийж, сөрөг нөлөөллийг бууруулах зөвлөмжийг гаргав. Төслийн төлөвлөгдсөн технологийн шийдэл, арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж, сөрөг нөлөөлөл, эрсдэлийг бууруулах талаарх мэргэжлийн байгууллагын зүгээс өгсөн санал, зөвлөмжийг мөрдөн ажилласан тохиолдолд сөрөг нөлөөллийн түвшин буурах боломжтой.

Төслийн барилгын ажил болон цаашдын үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг байгаль орчны бүрэлдэхүүн тус бүрээр нь ангилан тодорхойлов. Нөлөөллийн хамрах хүрээг бүс нутаг, аймаг, сум, төслийн талбай гэсэн үндсэн 4 түвшинд тодорхойлов.

Хүснэгт 3. Төслийн үйл ажиллагаанаас үүсэж болзошгүй сөрөг нөлөөллийн хамрах хүрээ

№	Болзошгүй нөлөөлөл	Бүс нутгийн түвшинд	Аймгийн түвшинд	Хороо буюу орон нутгийн түвшинд	Төслийн талбайн хэмжээнд	Нөлөөлөлд өртөх байгаль орчны бүрэлдэхүүн хэсэг
1	Уур амьсгалын өөрчлөлт	0	0	0	0	
	Агаарын чанарын өөрчлөлт	0	х	х	х	Агаар бохирдож болзошгүй
	Чимээ шуугиан	х	х	х	х	Дуу чимээ, доргилт ихсэх
	Гадаргын болон гүний усны нөөц, горим	0	0	х	х	Гүний худгаар ахуйн хэрэглээг хангана.
	Хөрсний чанар, геоморфологи	0	х	х	х	Хөрсний элэгдэл эвдрэл үүснэ.
2	Усны ургамал, амьтан	0	0	0	0	
	Эх, газрын ургамал, амьтан	0	0	0	х	Ургамлын бүтэц өөрчлөгдөх
	Тусгай хамгаалалттай газар нутаг	0	0	0	х	
	Дархан цаазтай амьтан, ургамлын төрөл зүйл	0	0	0	х	
3	Аж үйлдвэр, зам тээвэр	0	0	х	х	зам тээвэр нэмэгдэнэ.
	Орон нутгийн усан хангамж	0	0	х	х	Усны хангамж доголдож болзошгүй.
	Хаягдал усны менежмент	0	0	0	х	Хаягдал ус гарна
	Хатуу хог хаягдлын менежмент	0	х	х	х	Хог хаягдлын төрөл, хэмжээ нэмэгдэж болзошгүй.
	Эрчим хүчний хэрэглээ, хангамж	х	х	х	х	Хэрэглээ нэмэгдэх магадлалтай.
	Нийгэм-эдийн засгийн байдал	+	+	+	+	Ажлын байр, орлого нэмэгдэнэ.

4	Археологи, палеонтологи	0	0	0	0	
	Нийгмийн эрүүл мэнд, аюулгүй байдал	0	0	0	х	Агаарын бохирдлоос үүдэн өвчин эмгэг тохиолдож болзошгүй.

Жич: “Х”-сөрөг нөлөө үзүүлэх магадлалтай

“О”-нөлөө үзүүлэхгүй

“+”-эерэг нөлөө үзүүлэх тэмдгээр харуулав.

Хүснэгтээс харахад гаалийн хяналтын талбай төсөл нь том бүтээн байгуулалтын төсөл биш учраас бүс нутаг, аймгийн түвшинд дам байдлаар агаарын чанар, эрчим хүч, нийгэм эдийн засагт нөлөөлөхгүй. Харин сум орон нутаг, талбайн хүрээнд шууд болон дам байдлаар агаарын чанар, орон нутгийн ус хангамж, эрчим хүчний хэрэглээ, хог хаягдлын менежмент, нийгэм-эдийн засгийн байдал, нийгмийн эрүүл мэнд аюулгүй байдал зэрэгт нөлөөлж болзошгүй нь харагдаж байна. Энэхүү баганад бичсэн төслийн үйл ажиллагаанууд нь нөлөөлөл үзүүлж ч болно, үзүүлэхгүй ч байж болно. Нөлөөлөл гэдгийн ямар нэгэн урьдчилан сэргийлэх арга хэмжээ аваагүй, эсвэл нөлөөллийг бууруулах оролдлого хийгээгүй тохиолдолд ирээдүйд үүсэж болох нөхцөл байдал гэж ойлгож болно. Гэхдээ эдгээр нөлөөллүүд нь ихэнх тохиолдолд тухайн төслийн үйл ажиллагааны хувьд тодорхойлох боломжтой. Мөн нөлөөллийг нь өөрчлөх боломжтой байдаг.

Нөлөөлөл үзүүлж буй үйл ажиллагаа тус бүрийг (өөрөөр хэлбэл төслийн байгаль орчны асуудал тус бүрийг) үзүүлж буй нөлөөллийн хэмжээ, тархалтаар нь тодорхойлохын тулд харгалзах байгаль орчны элементтэй нь уялдуулан судлах шаардлагатай тул доорх хүснэгтээр харуулав.

Хүснэгт 4. Байгаль орчны нөлөөллийг тоймлох анхан шатны хүснэгт

	Байгаль орчны элементүүд	Байгаль орчны физик шинж чанар	Биологийн буюу экологийн нөөц	Хүний хэрэгцээний үнэ цэнэ	Амьдралын чанар
--	--------------------------------	--------------------------------------	--	-------------------------------	--------------------

	Үйл ажиллагаа	Агаарын чанар	Гадаргын усны төлөв байдал	Гүний усны төлөв байдал	Гадаргын болон гүний усны чанар	Усны ургамал, амьтан	Эх газрын ургамал, амьтан	Тусгай хамгаалалттай газар нутаг болон амьтан ургамлын төрөл зүйл	Хөдөө аж ахуй, мал аж ахуй	Газар ашиглалтын бусад төлөвлөлт	Орон нутгийн усны хангамж,	Орон нутаг дахь бохир усны менежмент	Орон нутаг дахь хатуу хог хаягдлын менежмент	Нийгэм, эдийн засгийн байдал	Аюулгүй байдал, эрүүл мэнд
1	Тоног төхөөрөмж, бараа материал буулгах	+	x	+	x	x	x	x	x	+	+	+	+	+	+
2	Тоног төхөөрөмж, бараа материал буулгаж ачих,	+	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	+

Дээрх хүснэгтэд "+", эсвэл "x" тэмдгээр тэмдэглэгдсэн нүднүүд нь төслийн үйл ажиллагаа, байгаль орчны хоорондын хамаарлыг харуулж байна. Хүснэгтээс харахад ачиж, буулгах, тээвэрлэх, үйл явцад агаарын чанарт болон ажилчдын аюулгүй байдал эрүүл мэндэд нөлөөлөл үзүүлж байна. Өөр бусад байгаль орчны хэсгүүдэд үзүүлэх нөлөөлөл бага байна. Төслийн үйл ажиллагаанаас үүдэх нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах ажлыг зохион байгуулахын тулд нөлөөллийн хэмжээг тодорхойлно. Хэрэв нөлөөллийн хэмжээ үлэмж их байвал цааш нарийн судалгаа хийх бөгөөд нөлөөллийн хэмжээ бага тохиолдолд цааш судлах шаардлагагүй. Нөлөөллийн хэмжээг 3 хүчин зүйлээр тодорхойлно.

Хүснэгт 5. Болзошгүй сөрөг нөлөөллийн хэмжээ. тархалтын түвшин

Хэмжээ тархалт (M) 1 , 2 ба 3	Агаарын бохирдол, дуу чимээний нөлөөлөл урт хугацаагаар үргэлжлэх болно.
Хамрах хүрээ (S) 1 , 2 ба 3	Төслийн үйл ажиллагааны нөлөөлөл нь сум орон нутаг, болон үйлдвэрийн талбайг хамарна.
Давтамж / магадлал (F) 1 , 2 ба 3	Тохиолдол нь тодорхой.

Гаалийн хяналтын талбайн үйл ажиллагааны болзошгүй нөлөөллийн агаарын бохирдол, хөрсөн бүрхэвчийн бохирдол, гүний усны бохирдлын шалгуур үзүүлэлт 6-12 байгаа нь нөлөөллийн түвшин багаас зэрэг, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн хэмжээг урьдчилан сэргийлж, бууруулан зохицуулах боломжтойг харуулж байна.

Хүснэгт 6. Хэмжээ, тархалтаар ерөнхийд нь үнэлсэн үнэгээ

Байгаль орчны асуудал	Болзошгүй нөлөөлөл: Хэмжээ, тархалтаар ерөнхийд нь үнэлсэн үнэлгээ: Бага, Дунд, Өндөр	Нөлөөллийн эрчим	
		MxSx F	Нийт үнэлгээ,эрчим
Үйлдвэрийн үйл ажиллагаа			
Ачилт, буулгалтын талбайн үйл ажиллагаанд, захиалагчдад нийлүүлэх явцад байгаль орчин хүний эрүүл мэндэд үзүүлж болзошгүй нөлөөлөл	Түүхий эд материалыг тээвэрлэх	2x2x2	6- бага
	Түүхий эд материалыг буулгах, ачих	2x2x2	6-бага
	Ачих явцад үүсэх дуу чимээ	2x2x2	6-бага

Өөрөөр хэлбэл нөлөөлөл нь нөлөөллийн эх үүсвэрээс тодорхой зайд янз бүрийн эрчимшилтэйгээр орон зайд тархана. Тухайлбал, нөлөөллийн эх үүсвэрээс тодорхой зайд нөлөөлөл их хэвээр үргэлжлэх ба нөлөөллийн төрлөөс шалтгаалан нөлөөллийн эрчимжил өөр өөр зайд ялгавартай буурна. Энэхүү орон зайд тархаж буй нөлөөллийн эрчим хоорондоо давхцах үед давхардмал нөлөөлөл үүсэх болно.

Мөн түүнчлэн байгаль орчин, нийгэм эдийн засагт үзүүлэх гол нөлөөллийн чанар, болзошгүй ослын хэмжээ, үргэлжлэх хугацаа, хамаарах хүчин зүйл, хамрах хүрээ зэргийг зааж өгөх шаардлагатай байдаг. Төслийн зүгээс үзүүлэх сөрөг нөлөөллийг байгалийн бүрэлдэхүүн тус бүрээр авч үзлээ.

Хүснэгт 7. Нөлөөллийн үнэлгээний систем

Нөлөөллийн эрчим	Үргэлжлэх хугацаа	Хамрах хүрээ	Магадлал
10 - Маш их	5 - Байнгын/Эргэж хивэндээ орохгүй	5 - Олон улсын хэмжээнд	5 – Гарцаагүй
8 – Их	4 - Урт хугацааны (нөлөөлөл нь үйл	4 - Үндэсний хэмжээнд	4 - Өндөр магадлалтай

	ажиллагааг хаасны дараа зогсоно)		
6 – Дунд	3 - Дунд хугацааны (5-15 жил)	3 - Бүс нутгийн хэмжээнд	3 - Дунд магадлалтай
4 – Бага	2 - Богино хугацааны (0-5 жил)	2 - Орон нутгийн хэмжээнд	2 - Бага магадлалтай
2 - Маш бага	1 - Түр зуурын	1 - Тухайн орчны хэмжээнд	1 – Тохиолдохгүй
1 - Нөлөөлөлгүй			0 – Үгүй
Хамгийн өндөр оноо нь 100 оноо гэж үзвэл >75 Нөлөөллийн зэрэглэл өндөр 30 to 75 Нөлөөллийн зэрэглэл дунд <30 Нөлөөллийн зэрэглэл бага байх болно.			

Нөлөөлөл тус бүрд эдгээр хүчин зүйлүүдийг эрэмбэлсний дараагаар үүсэх магадлал ба хор уршиг гэсэн 2 зүйлийн зэрэглэлийг доорх томъёог ашиглан тооцно:

Оноо = (Эрчим + Үргэлжлэх хугацаа + Хамрах хүрээ) x Магадлал

Онооны зэрэглэлийн хамгийн их утга нь 100 байна. Байгаль орчны боломжит нөлөөллүүдийг бууруулах арга хэмжээтэй уялдуулан Их, Дунд зэрэг, Бага гэж дараах байдлаар зэрэглэн ангилна.

>75	БО-нд нөлөөлөх зэрэглэл өндөр (Н) байгааг илтгэх	Энэ тохиолдолд ямар бууруулах арга хэмжээ байж болох вэ гэдгээс үл хамааран энэ нь төслийг эхлүүлэх эсэх талаар шийдвэр гаргахад нөлөөлнө.
30-75	БО-нд үзүүлэх нөлөөлөл Дунд зэрэг (М) байгааг илтгэх	Бууруулах арга хэмжээ төлөвлөхгүй л бол энэ нь төслийг эхлүүлэх шийдвэрт нөлөөлнө. Дунд зэрэглэлийн нөлөөлөл нь менежментийн төлөвлөгөө гаргахыг зайлшгүй шаарддаг. Хэрэв менежментийн төлөвлөгөө боловсруулахгүй бол төслийг эхлүүлэх эсэх талаарх шийдвэрт ч нөлөөлж болзошгүй.
<30	БО-нд үзүүлэх нөлөөллийн зэрэглэл Бага	Төслийг эхлүүлэх эсэх талаарх шийдвэрт нөлөө үзүүлэхгүй. Маш бага нөлөөлөл нь төслийн төлөвлөлт, дизайнд өөрчлөлт оруулахад хүргэдэггүй бөгөөд

	(L) байгааг илтгэх	бууруулах арга хэмжээний өөр хувилбаруудыг ашиглах шаардлагагүй байдаг.
+	Эерэг нөлөөлөл	Ийм нөлөөллийн дүнд эерэг үр дүнгүүд гардаг.

БҮЛЭГ 4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

“Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм.

Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт байрлах “Винтрак ХХК-ийн “Гаалийн хяналтын талбай” төслийн 2025 оны БОМТ-г Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 31-ны өдрийн А/618 дугаар тоот тушаалаар баталсан аргачлалыг баримтлан боловсруулсан болно.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгад зааснаар аливаа төслийг хэрэгжүүлэхдээ байгаль орчны менежментийн төлөвлөгөөг (цаашид БОМТ гэх) байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний үр дүнд үндэслэн түүнийг гүйцэтгэсэн мэргэжлийн байгууллага үнэлгээний эрх бүхий аж ахуйн нэгж боловсруулан, улмаар төсөл хэрэгжүүлэгчтэй зөвшилцөн, ерөнхий үнэлгээг хийсэн байгууллагаар хянуулах, батлагдсаны дараа хэрэгжилтийг хангаж ажиллах үүргийг тухайн төсөл хэрэгжүүлэгч хүлээхээр заасан. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тухайн төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлан төсөл хэрэгжүүлэх зөвшөөрлийг олгох, жил бүрийн хэрэгжилтийн тайланг хянаж дараа жилийн төлөвлөгөөг батлах замаар уг төлөвлөгөөний хэрэгжилтийг тогтмол хянаж байхаар тус тус зохицуулсан билээ.

Мөн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэд тухайн орон нутгийн байгаль хамгаалагч, байгаль орчны хяналтын улсын байцаагч, бүх шатны Засаг дарга, төрийн захиргааны төв байгууллага болон байгаль орчны төрийн бус байгууллага хяналт тавих эрхтэй бөгөөд тэдгээрт холбогдох мэдээллээ ил тод болгох, тодорхой хуваарийн дагуу хяналт хийх боломжийг бүрдүүлэх шаардлага мөн тавигдсан.

Винтрак ХХК-ийн гаалийн хяналтын талбайн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний явцад тогтоогдсон төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, түүнээс урьдчилан сэргийлэх, үр дагаврыг арилгах арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, зарцуулах төсөв, баримтлах эрх зүйн баримт бичиг зэргийг тодорхойлон нэгтгэж тусгав.

БҮЛЭГ 5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний явцад төслийн үйл ажиллагаанаас тухайн нутгийн байгаль орчинд үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, түүнээс урьдчилан сэргийлэх, үр дагаврыг арилгах арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлын хамт тодорхойлж, баримтлах хууль, дүрэм журам, стандартуудыг хамтатган байгаль хамгаалах төлөвлөгөөг боловсруулав. Төслийн талбайд 2025 онд хийхээр төлөвлөгдсөн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг “Винтрак” ХХК-ийн ажлын явцад үндэслэн боловсрууллаа.

Хүснэгт 8. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, бууруулах багасгах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Нэгжийн зардал, мян.төг	Тоо хэмжээ	Зардлын эх үүсвэр	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах хууль, журам, стандарт
Агаарын чанар								
1	Машин механизмаас ялгарах хорт утаа нь агаарын чанарт сөргөөр нөлөөлөх	Ашиглагдаж буй машин техникийг үзлэгт хамруулах, агаарын бохирдлын төлбөрийг төлөх	Төслийн талбай	-	-	Үйл ажиллагаа аны зардалд тусгах	2025 онд Жилд 1 удаа	MNS ISO4227-2002 Хүрээлэн буй орчны агаарын чанарын хяналтын төлөвлөгөө” MNS 5885-2008 Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ. Техникийн ерөнхий шаардлага MNS 4990-2000 ХААЗА. Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага
2	Хөрс хуулалт газар шорооны ажил явагдсанаар орчны агаарт тоосжилт үүсэх	10 м/с-ээс дээш хүчтэй салхитай үед газар шорооны ажлыг түр зогсоох	Төслийн талбай	-	-	-	Салхины хүч ихээр нэмэгдэх үед	
3	Талбайд нүүрс ачиж, буулгаж, хадгалах үед агаарт нүүрсний тоосжилт үүсэх	Тоосжилтыг бууруулах зорилгоор нүүрс ачиж буулгах талбайг тойруулан 8-12м өндөртэй салхинаас	Төслийн талбай	-	-	Үйл ажиллагаа аны зардалд тусгах	2025 онд	

Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутаг дэвсгэрт байрлах “Винтрак” ХХК-ийн
“Гаалийн хяналтын талбай” төслийн 2025 оны Байгаль орчны менежментийн
төлөвлөгөө

2025 он

		хамгаалах торон хашааг байгуулах, эвдрэл гэмтэл үүссэн тохиолдолд тухай бүрд хавсаргах Тоосжилтыг багасгах үүднээс төслийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны явцад төслийн төлөвлөлтөд тусгагдсан талбайг хатуу хучилттай болгох;						MNS 5013:2009 Бензин хөдөлгүүртэй автомашин. Утааны найрлага дах хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга MNS 5014:2009 Дизель хөдөлгүүртэй автомашин. Утааны тортогжилтын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга MNS ISO 3929 : 2014 Авто тээврийн хэрэгсэл.
4	Машин механизмын хөдөлгөөнөөс агаарт тоосжилт үүсэх	Тоосжилт дарах зам усалгаа	Нийт талбайд	1000.0	12	-	Цаг агаарын нөхцөл байдалтай уялдуулж 2025 онд жилд дор хаяж 10 удаа	
Хөрсөн бүрхэвч								
		Хог хаягдлын цэгийг зориулалтын сав талбайг зохих шаардлагын дагуу салхины ноёлох чиглэлийн доор байрлуулах	Төслийн талбай дотор	700.0	1	700.0	2025 онд	MNS 3307:1991, MNS 3308:1991 Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга, MNS 5850:2008 Хөрс бохирдуулагч бодис,
		Хөрсөнд шатах тослох материал алдагдахаас сэргийлж гэмтэл, эвдрэлтэй машин техникийг ажлын	Төслийн талбай дотор	670.0			Жил бүр	

Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутаг дэвсгэрт байрлах “Винтрак” ХХК-ийн
“Гаалийн хяналтын талбай” төслийн 2025 оны Байгаль орчны менежментийн
төлөвлөгөө

2025 он

		талбайд гаргахгүй байх, засвар үйлчилгээг тогтмол хийх				элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
Ургмалан нөмрөг						
7	Хүн болон машин механизмуудын замбараагүй хөдөлгөөнөөс болоод ургамлан нөмрөг доройтох	Үйл ажиллагааны нөлөөлөлд өртөөгүй газруудад зөвшөөрөлгүй автомашин, машин механизмуудын хөдөлгөөнийг хориглох төслийн талбайд явган хүний болон машин техникийн хөдөлгөөний зам, маршрутыг тогтоож, тэмдэгжүүлэх, даган мөрдөх	Төслийн талбай	“Винтрак ХХК-ийн өдөр тутмын үйл ажиллагаанд орно	Жил бүр	
8	хатуу хучилттай болгосноор ургамлан нөмрөг устаж шууд нөлөөлөлд өртөнө	Төслийн талбайд олон наст ургамал тарьж, зүлэгжүүлэх, мод тарих ажлыг мэргэжлийн байгууллагын тусламжтайгаар хийж гүйцэтгэх	Төслийн талбай дотор	Ногоон байгууламжийн зардалд тусгасан.		
Усан орчин						
9	Төслийн талбай, барилгын эргэн тойрны газарт хатуу хог хаягдал хуримтлагдах, гүний усанд бохирдол үүсэх	Унд, ахуйн хэрэглээний усанд тогтмол шинжилгээ хийлгэж байх	Унд, ахуйн хэрэглээний усан хангамж	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгагдсан	Жил бүр	MNS 0900:2018 Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага,

Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутаг дэвсгэрт байрлах “ Винтрак” ХХК-ийн
“Гаалийн хяналтын талбай” төслийн 2025 оны Байгаль орчны менежментийн
төлөвлөгөө

2025 он

						чанар, аюулгүй байдлын үнэлгээ
Амьтны аймаг						
10	Төслийн талбай түүний ойр орчимд хог хаягдлыг ил задгай цуглуулснаас мал амьтад тэжээл хайж ирэх орогнох, хордож болзошгүй	Хог хаягдлыг ангилан зориулалтын битүү саванд байршуулах,битүүмжлэ лийг г байнга хянаж шалгах	Төслийн талбай орчим	Үйл ажиллагааны зардлаар		МУ-ын хууль хууль, Амьтны тухай хууль, БО-ны багц хуулиуд
Нийт дүн				2370.0		

БҮЛЭГ 6. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний, орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөөнд үйлдвэрийн талбайн сул чөлөөтэй хэсэг буюу эргэн тойронд мод бут сөөг тарих нөхөн сэргээх ажлыг MNS 4918:2000 стандартын дагуу ургамалжуулалт, ногоон байгууламж, мод тарих ажлыг үйл ажиллагааг эхлүүлэхээр төлөвлөсөн.

Хүснэгт 9. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө

Материалын нэр		Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгж үнэ, төг	1 жилийн Нийт үнэ, мян.төг	тайлбар
1	Ажилчдын хотхонд хайлаас тарих	ш	100	11250	1125.0 төг	Говийн нөхцөлд хөрс голохгүй тэсвэр сайтай ургах мод юм.
2	Усалгааны хэмжээ	М³	3.9	4000	15.06 м3	100ш модны усалгааг тооцохдоо $100 \times 30 \text{ л} = 3000 \text{ л} / 1000 = 3 \text{ м}^3$ 7 хоногт 2 удаа услахаар $3 \text{ м}^3 \times 2 = 6 \text{ м}^3$
3	Услах машины түлшний зардал	л	7.5	4500	Нэг удаа 33.7 төг	Сумын төвөөс 15 км-ын зайтай худгаас ус авах бөгөөд 7 хоногт 1 удаа явах ба нийт 30 км явах зардлыг тооцсон болно.
4	Арчилгаа, усалгааны зардал	Жилд	2	100.0	200.0 төг	Модны зэрлэг, тогоог томруулж усалгааг шалгаж, арчилгаа хийх.
Нийт					1358.7	

Тэрбум мод үндэсний хүрээнд:

Хүснэгт 10. Тэрбум модны зардлын задаргаа

Материалын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгж үнэ, төг	1 жилийн Нийт үнэ, мян.төг	Тайлбар
Тэрбум модны хүрээнд орон нутгийн заасан талбайд мод тарих 0.8-1.2 м өндөртэй 2-3 настай хайлаас мод	ш	500	11250	5625.0	Тэрбум модыг Сумын засаг дарга болон байгаль орчны мэргэжилтнээс санал авч талбайг тогтооно. Усалгааны зардлыг сум орон нутаг хариуцна.

БҮЛЭГ 7. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Тус төслийн төлөвлөгөөний дагуу одоогоор түүх, соёлын өв илрээгүй. Төслийн үйл ажиллагааны явцад археологи, палеонтологийн олдвор, түүх соёлын дурсгалт зүйлс илэрвэл үйл ажиллагаагаа түр зогсоож энэ тухай сум, дүүргийн засаг дарга, цагдаагийн болон уг асуудлыг эрхэлсэн эрдэм шинжилгээний байгууллагад нэн даруй мэдэгдэх ба цаашид Монгол улсын “Соёлын өвийг хамгаалах тухай хууль” болон бусад холбогдох хууль тогтоомжийг мөрдөн ажиллана.

Хүснэгт 11. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

№	Нөлөөлөлд өртөх түүх, соёлын өв	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мян. төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Археологийн болон Палеонтологийн дурсгал	Төслийн барилга байгууламжийн ажлын үед соёлын биет өв илэрвэл төсөл хэрэгжүүлэгч нь ажлаа зогсоож, Энэ тухай сумын Засаг дарга, цагдаагийн болон уг асуудлыг хариуцсан байгууллагад мэдэгдэх.	Төслийн талбайд	-	-	2025 он	МУ-ын Соёлын өвийн тухай хуулийн 38.3
Нийт дүн					-		

БҮЛЭГ 8. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Энэхүү төслийн талбай нь Өмнөговь аймгийн Ханбогд сумын 5-р багт байрлана. “Гаалийн хяналтын ” талбайн үйл ажиллагааны явцад ажилчдын аюулгүй байх орчин нөхцөлийг ханган хөдөлмөр хамгаалал, осол аюулгүйн талаарх арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай.

Хүснэгт 12. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, бууруулах багасгах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Нэгжийн зардал, мян.төг	Тоо хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах хууль, журам, стандарт
1	Болзошгүй осол, саатал, техник тоног, төхөөрөмжийн гэнэтийн аюул үүсэх	Техник, технологийн аюулгүй байдлыг тогтмол шалгах, хянах	Төслийн хүрээнд ашиглагдах тоног төхөөрөмж, техник	Төслийн өдөр тутмын үйл ажиллагаа		2025	Гамшгаас хамгаалах тухай хууль
		Байгаль орчныг хамгаалах талаар сургалтыг зохион байгуулах, холбогдох дүүргийн байгаль орчны алба, байгаль хамгаалагч нартай харилцан холбоотой ажиллах	Нийт ажилчид	Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээнд тусгасан		2025	
2	Ажилчдын эрүүл мэнд аюулгүй ажиллагаа	Яаралтай анхны тусламжид шаардлагатай эм тариа, багаж хэрэгсэлд худалдан авч байршуулах	Үйлдвэр	220.0	-	2025	MNS 5029:2011. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Химийн хорт болон аюултай бодисын шошго, анхааруулах тэмдэг.

Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутаг дэвсгэрт байрлах “Винтрак” ХХК-ийн
“Гаалийн хяналтын талбай” төслийн 2025 оны Байгаль орчны менежментийн
төлөвлөгөө

2025 он

		Ажиллагсдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэглэлээр, хангах	Нийт ажилчид	350.0	-	2025	“Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль”-ийн 15-дугаар зүйл
		Аюулгүй ажиллагааны дотоод журам боловсруулж мөрдүүлэх	Талбайн хэмжээнд	Үйл ажиллагааны зардлаар		2025	“Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль”-ийн 27.3.4, 28.1.8
		Гэнэтийн осол аваар , гал түймэр, усны аюул мэтийн гэнэтийн ослоос урьдчилан сэргийлэх, осол гарсан тохиолдолд шуурхай хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах талаар сургалт, судалгааны ажлыг мэргэжлийн байгууллага хүмүүстэй хамтран зохион байгуулах	Нийт ажилчид	Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээнд тусгасан		2025	
	Машин, техник хэрэгслийн эвдрэл гэмтэл гарах	Машин, техник хэрэгслийг тогтмол шалгаж засвар үйлчилгээг тогтмол хийх, бүртгэл хөтлөх.	Төслийн талбай	480.0		Үйл ажиллагааны туршид тогтмол	
Нийт				1050.0			

БҮЛЭГ 9. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Винтрак ХХК нь үйл ажиллагаанаасаа гарч буй хог хаягдлын хэмжээг багасгах, аль болох бага хог хаягдал үүсгэх, түүнийг дахин ашиглах болон дахин боловсруулах замаар гарсан хог хаягдлын хэмжээг бууруулах, үлдсэн хог хаягдлыг хүрээлэн буй орчинд аюулгүй байдлаар устгах 3R зарчмыг баримтлан ажиллах шаардлагатай. Хог хаягдлын сөрөг нөлөөлөл болон түүний хэмжээг бууруулахад менежментийн төлөвлөгөөний 1 жилийн хугацаанд 1.050.000 төгрөг зарцуулахаар төлөвлөсөн.

Хүснэгт 13. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
АХУЙН	Харьяа газрын ТҮК-тэй хийсэн хог тээрийн гэрээний дагуу зайлуулах	Хүрээлэн буй орчин, хүний эрүүл мэнд	тн	1 м3 хог хаягдал 12500 Сард 4 удаа тээвэрлэнэ. Сард 50.0 жилд 600.0	ҮАЗ		2025	UCS 1701A:2022 “Хог хаягдлыг цуглуулах, ангилах, хадгалах, тээвэрлэх арга зүйн менежмент” хотын стандарт “Хог хаягдлын тухай” хууль, “Энгийн хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах
	Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилах ялгах хогийн сав авч байршуулах		ш	280.0	1	-	2025	
	Харьяа газарт байрлах мэргэжлийн байгууллагатай бохир ус соруулж зайлуулах гэрээ байгуулах		Тн 7 хоногт 1 удаа	1 удаагийн бохир соруулах 30.0 Сард 4 удаа тээвэрлэнэ. Сард 120.0 жилд 720.0 /6 сараар тооцов/			2025	

АЮУЛТАЙ	Хатуу шингэн хог хаягдлын цэгүүдэд ариутгал, халдваргүйжүүлэлт хийх	Хог хаягдлын цэг	Удаа	12.5	улирал д 1 удаа	4*12.5=50.0	2025	үйл ажиллагаанд тавигдах ерөнхий шаардлага” (БОАЖС-ын 2018 оны А/443 дугаар тушаал). “Хог хаягдлын улсын мэдээллийн нэгдсэн сангийн тогтолцоо, бүрдэл болон мэдээлэл төвлөрүүлэх журам” “Нүхэн жорлон,угаадасны нүх. Техникийн шаардлага ” MNS 5924 : 2015
Нийт						1050.0		

БҮЛЭГ 10. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Тухайн төслийг хэрэгжүүлснээс үүдэн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг тухай бүр илрүүлэх, бууруулах, арилгах зорилгоор байгаль орчны төлөв байдал, шинээр үүсэн бий болсон нөхцөл байдалд ажиглалт, хяналт явуулах үйл ажиллагааны удирдамжийг **“Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр”** гэнэ. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тухайн төслөөс байгаль орчны бүрэлдэхүүн хэсэг /ус, хөрс, ургамал гэх мэт/ тус бүрд гарах бохирдол, аливаа өөрчлөлтийг хянах шинжилгээний арга аргачлал, хяналт шинжилгээ хийх хугацаа, сорьц авах болох хэмжилт хийх цэгийн байршил, баримтлах стандартууд зэргийг тодорхойлно.

Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөр нь төслийг хэрэгжүүлэх явцад үүссэн сөрөг нөлөөлөл, түүнийг бууруулах үйл ажиллагаа ямар үр дүнтэй байгааг илтгэх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний үндэслэлийг боловсруулах, байгаль хамгаалах төлөвлөгөөг улам боловсронгуй болгох, байгаль орчноо хамгаалах, орон нутгийн захиргаа, хяналтын болон нутгийн оршин суугчдад бодитой мэдээлэл өгөхөд чухал ач холбогдолтой. ОХШХ нь БОХТ-тэйгээ нягт уялдсан бөгөөд байгаль орчныг хамгаалахаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний үр дүнг илэрхийлж, уг авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ үр ашигтай байгаа эсэхэд үнэлэлт дүгнэлт өгөх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүдэд юуг анхаарах шаардлагатайг зааж өгнө. Байгаль орчныг хамгаалах тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай Монгол Улсын хуулиудын дагуу батлагдсан арга, аргачлалаар, итгэмжлэгдсэн тоног төхөөрөмжөөр байгаль орчны хяналт шинжилгээний ажлыг явуулах шаардлагатай.

Тухайн жилд хийсэн хяналт шинжилгээний үр дүнгүүдийг жил бүрийн 12 дугаар сарын 1-ний дотор холбогдох төрийн захиргааны төв байгууллага /Байгаль орчин, аялал жуулчлалын яам/-д хүргүүлэн хянуулж, дараа оныхоо төлөвлөгөөг батлуулж ажиллах ёстой. Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлэх, батлагдсан арга, аргачлалаар дээжлэлт, хэмжилт хийх, холбогдох нарийвчлал, тохиргоог хангасан багаж тоног төхөөрөмжөөр шинжилгээг хийлгэх, үр дүнг шаардагдах нэгжийн системээр гаргах зэрэг бүхий л үйл ажиллагааг “Винтрак” ХХК хариуцах болно.

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт нөлөөлөлд өртөх болон өртөж болзошгүй байгаль орчны бүрдэл хэсгүүд, тэдгээрийн төлөв байдлыг тодорхойлох үзүүлэлтүүд, тэдгээрт хэмжилт, дээжлэлт хийх шинжилгээний аргууд, хяналтын цэгийн байршил, хяналт хийх хугацаа ба давтамж зэргийг ажлын хэмжээг хэмжих нэгж, нэгжийн үнэ, нийт зардал, баримтлах стандарт, аргазүй, аргачлалын хамт тусгаж боловсруулан оруулна. Төмөр бетон эдлэлийн үйлдвэрийн талбайн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийн цар хүрээ, эрчмийг харгалзан үзэж, төслийн талбай болон түүний орчны бүсийн талбайг хамран байгаль орчны хяналт шинжилгээг жил бүр тогтмол хийж байх хэрэгтэй.

Хүснэгт 14. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Бүрэлдэхүүн	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Байршил	Хугацаа ба давтамж	Нэгжийн өртөг, мян.төг	Нийт зардал мян/жил	Баримтлах стандарт ба арга аргачлал
Агаарын чанар	Нүүрстөрөгчийн исэл, Хүхэрт устөрөгч, Азотын давхар исэл, тоос, дуу чимээ	Талбай дотор 2 цэгт гадна 1 цэгт	Жил бүр нэг удаа Шаардлагатай тохиолдолд тухай бүрд нь.	(SO ₂ , NO ₂ , CO , цаг агаарын үзүүлэлт)-ийг хамт тооцоход 60.0 мян.төг Тайлбар: Тоос тоосонцрын хэмжилтийн зардлыг БОАЖ-ын сайдын 2019 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн А/164 дугаар тушаалын хавсралтаар тооцов.	360.0 мян.төг	– MNS3113:1981. Агаар мандлын бохирдлыг хэмжих аргачлалын ерөнхий шаардлага – MNS0017-2-3-16:1988. Агаар мандал-Хот, суурингийн агаарын бохирдлын шинжилгээ – MNS3384:1982. Агаар мандал-Агаарын дээжилт шинжилгээ – MNS3113:1981. Хорт утааны ялгаралтыг хэмжих арга – MNS5061:2001. Нүүрс хүчлийн хий-CO₂ тодорхойлох эзлэхүүний арга – MNS0012-014:1991. Ажлын байрны агаар-Бичил орчинг шинжлэх арга
Хөрсөн бүрхэвч	хөрсний үе давхаргын зузаан (см), элэгдэл эвдрэлийн нөхцөл, ялзмаг %, pH, давсжилт, Физик шинж чанар, органик бодис, нийт азот, карбонат, Ca, Mg, P ₂ O ₅ , K ₂ O, хөрсний	Талбай дотор 2 цэгт гадна 1 цэгт	Жилд нэг удаа	Хөрсний механик бүрэлдэхүүн, ялзмаг 30.0 мян.төг Хөрсний хүнд металл шинжилгээний үнэ 62.0 мян.төг Эрүүл ахуйн шинжилгээ 35.0 мян.төг	662.0	– MNS3985-87 Хөрсний ариун цэврийн байдлын үзүүлэлтийн нэр, төрөл – MNS3310-91 Хөрсний агро химийн үзүүлэлтийг тодорхойлох – MNS2305-94 Дээж авах, савлах, тээвэрлэх, хадгалах журам – MNS(ISO)4814:1999. Атом Шингээлтийн Спектрометрээр шинжилгээ хийх

	зарим хүнд металлын агууламж			<i>*Эс жи Эс лаб ХХК үнэ аваг.</i>		
Дээж хэмжилт авах томилолтын зардал	Улаанбаатараас руу явах тээврийн зардал, томилолтын зардал 800 км		Жилд нэг удаа	800.0	ҮАЗ	–
Ажиллагсдын эрүүл мэндийн хяналт үнэлгээ	Мэргэжлийн өвчин судлалын үндэсний төвтэй гэрээ байгуулж ажиллана.		Жил бүр	хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн хөтөлбөрт тусгагдсан.	ҮАЗ	Ажлын байрны нөхцөл, эрүүл ахуй, хөдөлмөрийн нөхцөл болон аюулгүй ажиллагааны талаар баримталдаг Монгол улсын стандартууд
	Нийт				1022.0 мян.төг	

Зураг 4. Дээж авах цэгийн байршил



БҮЛЭГ 11. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөнд Байгаль орчныг хамгаалах, үйлдвэрлэлийн осол, гал түймэр, усны аюул мэтийн ослоос урьдчилан сэргийлэх, осол гарсан тохиолдолд шуурхай хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах талаар 1 жилд 1 удаа сургалт, сурталчилгааны ажлыг мэргэжлийн байгууллагын хүмүүстэй хамран зохион байгуулахаар төлөвлөсөн.

Хүснэгт 15. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь	Хариуцсан албан тушаалтан
			2025 он	
1	БОМТ-д тусгасан байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг тодорхой албан тушаалтанд хариуцуулан үйл ажиллагааг зохион байгуулах, дотоод журам тогтоож мөрдөх	Дотоод зохион байгуулалтаар	Үйл ажиллагааны хугацаанд	“Винтрак” ХХК-ийн удирдлага
2	Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээг зохих хугацаанд нь хийж гүйцэтгэх ба биелэлтийг жил бүр дүгнэж, дүнг байгаль орчны хяналтын байгууллагад хүргүүлэх	Дотоод зохион байгуулалтаар	Үйл ажиллагааны хугацаанд	“Винтрак” ХХК-ийн удирдлага
3	ХАБЭА дүрмийн дагуу үзлэг, шалгалтыг тогтмолжуулж илэрсэн зөрчлийг тухай бүр арилгах ажлыг зохион байгуулах	Дотоод зохион байгуулалтаар	Сар бүр	“Винтрак” ХХК-ийн удирдлага
4	Байгаль хамгаалахад орон нутгийн оролцоог идэвхжүүлэх, уулзалт зөвлөгөөг жил бүр зохион байгуулах, тэдний санал зөвлөмжийг БОМТ-нд тусгах	1 жилд 70.0	10 сард	“Винтрак” ХХК-ийн удирдлага

5	Байгаль орчныг хамгаалах талаар сургалтыг зохион байгуулах, холбогдох сум, дүүргийн байгаль орчны алба, байгаль хамгаалагч нартай харилцан холбоотой ажиллах	500.0	Үйл ажиллагааны хугацаанд	“Винтрак” ХХК-ийн удирдлага
6	Гэнэтийн осол аваар , гал түймэр, усны аюул мэтийн гэнэтийн ослоос урьдчилан сэргийлэх, осол гарсан тохиолдолд шуурхай хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах талаар сургалт, судалгааны ажлыг мэргэжлийн байгууллага хүмүүстэй хамтран зохион байгуулах	500.0	Үйл ажиллагааны хугацаанд	“Винтрак” ХХК-ийн удирдлага
7	Төслийн техник, технологид энэхүү тайланд тусгагдсанаас өөр нэмэлт өөрчлөлт орох бүрд дахин байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний нэмэлт тодотгол хийлгэх шаардлагатай	Дотоод зохион байгуулалтаар	Үйл ажиллагааны хугацаанд	“Винтрак” ХХК-ийн удирдлага
8	Төсөл хэрэгжих орон нутгийн удирдлагатай нийгмийн хариуцлагын хүрээнд хамтран ажиллах	500.0	Үйл ажиллагааны хугацаанд	“Винтрак” ХХК-ийн удирдлага
Нийт		1570.0		

БҮЛЭГ 12. 2025 ОНЫ БОМТ-ИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ХУВААРЬ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчдад тайлагнахдаа 2025 оны 10 сард Ханбогд сумын иргэдэд танилцуулна.

Хүснэгт 16. БОМТ-ний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь

БОМТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацаа	Тайлагнах зардал, мян.төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан
Өмнөговь аймгийн Байгаль орчны газар	Хэвлэмэл хэлбэрээр	БОМТ-ний биелэлтийг тайлагнах,	Жил бүрийн 11 сарын 01	200.0	“Винтрак” ХХК-ийн удирдлага
Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам	Хэвлэмэл хэлбэрээр	БОМТ-ний биелэлтийг тайлагнах	Жил бүрийн 12 сарын 01	110.0	Винтрак” ХХК-ийн удирдлага
Нөлөөлөлд өртөгч оршин суугчид	Хэвлэмэл хэлбэрээр	БОМТ-ний биелэлтийг тайлагнах	Жил бүрийн 12 сарын 01	200.0	“Винтрак” ХХК-ийн удирдлага
Нийт				510.0	

ДҮГНЭЛТ

“Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм.

Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт байрлах “Винтрак ХХК-ийн “Гаалийн хяналтын талбай” төслийн 2025 оны БОМТ-г Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 31-ны өдрийн А/618 дугаар тоот тушаалаар баталсан аргачлалыг баримтлан боловсруулсан болно.

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний явцад төслийн үйл ажиллагаанаас тухайн нутгийн байгаль орчинд үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, түүнээс урьдчилан сэргийлэх, үр дагаврыг арилгах арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлын хамт тодорхойлж, баримтлах хууль, дүрэм журам, стандартуудыг хамтатган байгаль хамгаалах төлөвлөгөөг боловсруулав. Төслийн талбайд 2025 онд хийхээр төлөвлөгдсөн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг “Винтрак” ХХК-ийн ажлын явцад үндэслэн боловсрууллаа.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний, орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөөнд үйлдвэрийн талбайн сул чөлөөтэй хэсэг буюу эргэн тойронд мод бут сөөг тарих нөхөн сэргээх ажлыг MNS 4918:2000 стандартын дагуу ургамалжуулалт, ногоон байгууламж, мод тарих ажлыг үйл ажиллагааг эхлүүлэхээр төлөвлөсөн.

Тус төслийн төлөвлөгөөний дагуу одоогоор түүх, соёлын өв илрээгүй. Төслийн үйл ажиллагааны явцад археологи, палеонтологийн олдвор, түүх соёлын дурсгалт зүйлс илэрвэл үйл ажиллагаагаа түр зогсоож энэ тухай сум, дүүргийн засаг дарга, цагдаагийн болон уг асуудлыг эрхэлсэн эрдэм шинжилгээний байгууллагад нэн даруй мэдэгдэх ба цаашид Монгол улсын “Соёлын өвийг хамгаалах тухай хууль” болон бусад холбогдох хууль тогтоомжийг мөрдөн ажиллана.

Энэхүү төслийн талбай нь Өмнөговь аймгийн Ханбогд сумын 5-р багт байрлана. “Гаалийн хяналтын” талбайн үйл ажиллагааны явцад ажилчдын аюулгүй байх орчин нөхцөлийг ханган хөдөлмөр хамгаалал, осол аюулгүйн талаарх арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай.

Винтрак ХХК нь үйл ажиллагаанаасаа гарч буй хог хаягдлын хэмжээг багасгах, аль болох бага хог хаягдал үүсгэх, түүнийг дахин ашиглах болон дахин боловсруулах замаар гарсан хог хаягдлын хэмжээг бууруулах, үлдсэн хог хаягдлыг хүрээлэн буй орчинд аюулгүй байдлаар устгах 3R зарчмыг баримтлан ажиллах шаардлагатай. Хог хаягдлын сөрөг нөлөөлөл болон түүний хэмжээг бууруулахад менежментийн төлөвлөгөөний 1 жилийн хугацаанд 1.050.000 төгрөг зарцуулахаар төлөвлөсөн.

Тухайн төслийг хэрэгжүүлснээс үүдэн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг тухай бүр илрүүлэх, бууруулах, арилгах зорилгоор байгаль орчны төлөв байдал, шинээр үүсэн бий болсон нөхцөл байдалд ажиглалт, хяналт явуулах үйл ажиллагааны удирдамжийг **“Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр”** гэнэ. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тухайн төслөөс байгаль орчны бүрэлдэхүүн хэсэг /ус, хөрс, ургамал гэх мэт/ тус бүрт гарах бохирдол, аливаа өөрчлөлтийг хянах шинжилгээний арга аргачлал, хяналт шинжилгээ хийх хугацаа, сорьц авах болох хэмжилт хийх цэгийн байршил, баримтлах стандартууд зэргийг тодорхойлно.

Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөр нь төслийг хэрэгжүүлэх явцад үүссэн сөрөг нөлөөлөл, түүнийг бууруулах үйл ажиллагаа ямар үр дүнтэй байгааг илтгэх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний үндэслэлийг боловсруулах, байгаль хамгаалах төлөвлөгөөг улам боловсронгуй болгох, байгаль орчноо хамгаалах, орон нутгийн захиргаа, хяналтын болон нутгийн оршин суугчдад бодитой мэдээлэл өгөхөд чухал ач холбогдолтой. ОХШХ нь БОХТ-тэйгээ нягт уялдсан бөгөөд байгаль орчныг хамгаалахаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний үр дүнг илэрхийлж, уг авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ үр ашигтай байгаа эсэхэд үнэлэлт дүгнэлт өгөх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүдэд юуг анхаарах шаардлагатайг зааж өгнө. Байгаль орчныг хамгаалах тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай Монгол Улсын хуулиудын дагуу батлагдсан арга, аргачлалаар, итгэмжлэгдсэн тоног төхөөрөмжөөр байгаль орчны хяналт шинжилгээний ажлыг явуулах шаардлагатай.

Тухайн жилд хийсэн хяналт шинжилгээний үр дүнгүүдийг жил бүрийн 12 дугаар сарын 1-ний дотор холбогдох төрийн захиргааны төв байгууллага /Байгаль орчин, аялал жуулчлалын яам/-д хүргүүлэн хянуулж, дараа оныхоо төлөвлөгөөг батлуулж ажиллах ёстой. Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлэх, батлагдсан арга, аргачлалаар дээжлэлт, хэмжилт хийх, холбогдох нарийвчлал, тохиргоог хангасан багаж тоног төхөөрөмжөөр шинжилгээг хийлгэх, үр дүнг шаардагдах нэгжийн системээр гаргах зэрэг бүхий л үйл ажиллагааг “Винтрак” ХХК хариуцах болно.

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт нөлөөлөлд өртөх болон өртөж болзошгүй байгаль орчны бүрдэл хэсгүүд, тэдгээрийн төлөв байдлыг тодорхойлох үзүүлэлтүүд, тэдгээрт хэмжилт, дээжлэлт хийх шинжилгээний аргууд, хяналтын цэгийн байршил, хяналт хийх хугацаа ба давтамж зэргийг ажлын хэмжээг хэмжих нэгж, нэгжийн үнэ, нийт зардал, баримтлах стандарт, аргазүй, аргачлалын хамт тусгаж боловсруулан оруулна. Төмөр бетон эдлэлийн үйлдвэрийн талбайн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийн цар хүрээ, эрчмийг харгалзан үзэж, төслийн талбай болон түүний орчны бүсийн талбайг хамран байгаль орчны хяналт шинжилгээг жил бүр тогтмол хийж байх хэрэгтэй.

Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөнд Байгаль орчныг хамгаалах, үйлдвэрлэлийн осол, гал түймэр, усны аюул мэтийн ослоос урьдчилан сэргийлэх, осол гарсан тохиолдолд шуурхай хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах талаар 1 жилд 1 удаа сургалт, сурталчилгааны ажлыг мэргэжлийн байгууллагын хүмүүстэй хамран зохион байгуулахаар төлөвлөсөн.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчдад тайлагнахдаа 2025 оны 10 сард Ханбогд сумын иргэдэд танилцуулна.

Хүснэгт 17. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал

№	Ажлын нэр	2025 оны Зардал (мян.төг)
1	Сөрөг нөлөөллийг бууруулах хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	2370.0
2	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө	1358.7
3	Тэрбум мод	5625.0
4	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	1050.0
5	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	1050.0
6	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	1022.0
7	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	1570.0
8	Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	510.0
Нийт дүн		14555.7

Винтрак ХХК нь 2025 оны байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөөнд 14555.7 мян.төг зарцуулахаар төлөвлөлөө. Байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9-р бүлэгт заасны дагуу тухайн жилийн байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөөг БОАЖЯ сайдын 2019 оны 10-р сарын 29-ны өдрийн А618 тоот тушаалаар батлагдсан аргачлалын дагуу Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансанд байршууллаа.




Цахим гүйлгээний баримт

Хүсэлтийн лавлах дугаар: 370933575

Татсан огноо: 2025-10-13 15:13

Шилжүүлэгчийн дансны дугаар	Хүлээн авагчийн данс	Гүйлгээний дүн	Гүйлгээний төлөв
3635138806 MN060015003635138806	MN650090100111055410 MN650090100111055410	7,277,850.00 MNT	Амжилттай
Шилжүүлэгчийн нэр ВИНТРАК	Хүлээн авагчийн нэр ӨМ.ХАНБОГД БАРЬЦАА	Гүйлгээний утга 5018439 Винтрак ХХК барьцаа төлбөр	
	Хүлээн авагчийн банк Төрийн сан	Гүйлгээний огноо 2025-10-13	

Гүйлгээг шивсэн хэрэглэгч	Гүйлгээг хянасан хэрэглэгч	Гүйлгээг баталсан хэрэглэгч
Н. Амаржаргал	Г. Ганцэцэг	Г. Ганцэцэг



Бүх эрх хуулиар хамгаалагдсан © . Голомтбанк ХК.